# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
# ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 3 дугаар сарын 26-ны өдөр | Дугаар 44 | Улаанбаатар хот

Ард даатгал" ХХК-ийн дүрмийн сангийн бүтцийн өөрчлөлтийг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.3, Даатгалын тухай хуулийн 21.5 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ: л

1. Иргэн Булган овогтой Мөнхөөгөөс иргэн Дагвабалжир овогтой Чулуунцэцэгт "Ард даатгал" ХХК-ийн нийт хувьцааны 20 хувийг №09/030/01 тоот хувьцаа шилжүүлэх, худалдах, худалдан авах гэрээний үндсэн дээр шилжүүлсэнээр "Ард даатгал" ХХК-ийн дүрмийн сангийн өөрчлөлтийг доорх хүснэгтэд дурдсанаар өөрчилсөнийг зөвшөөрсүгэй.

| Хувь нийлүүлэгчдийн хувь | | Эзэмших хувьцаа | | |
|---|---|---|---|---|
| | | Тоо ширхэг | Бүгд үнэ/мянган төгрөг/ | Дүрмийн санд эзлэх хувь |
| 1 | Ц.Тогтохбаяр | 53536 | 174 039 700 | 34.8 |
| 2 | Б.Мөнхөө | 18240 | 59 293 620 | 11.9 |
| 3 | Омни Виттонгтон | 51268 | 166 666 680 | 33.3 |
| 4 | Д.Чулуунцэцэг | 30760 | 100 000 000 | 20.0 |
| | Дүн | 153804 | 500 000 000 | 100 |

2. "Ард даатгал" ХХК-ийн нийт хувьцааны 20 хувийг эзэмшигч болсон иргэн Дагвабалжир овогтой Чулуунцэцэгт холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/-т даалгасугай.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА О.ГАНБАТ